



ХОВД АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 35-02/18

Ховд

ХОВД АЙМГИЙН БУЯНТ СУМЫН ТӨСӨВТ
БАЙГУУЛЛАГУУДЫН 2021-2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН
ТАНИЛЦУУЛГА

Нэг. Шалгалтын зорилго

Аймгийн Засаг даргын баталсан 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 35-01/03 тоот удирдамж 2023 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны дарга, улсын ахлах байцаагч, дотоод аудитор нар Ховд аймгийн Буянт сумын төсөвт байгууллагуудын 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаа, төрийн өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын байдал, төсөв санхүү нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан ажиллахад оршино.

Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга бөгөөд санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч Г.Өөдэй, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч Ж.Цэнд-Аюуш, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч П.Мягмартүвшин, Н.Балт, У.Гандэмбэрэл, дотоод аудитор Д.Пүрэвдулам нар 2023 оны 04 дүгээр сарын 17- ний өдрөөс ажлын 12 хоногт хяналт шалгалтаар ажиллав.

Гурав. Шалгалтад хамрагдсан асуудал

Тус байгууллагуудын 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагааг Монгол улсын санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн болон бусад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас

230026

гаргасан заавар журмын хэрэгжилт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, үндсэн баримт материал, тайлан тэнцэлд тулгуурлан явуулав.

Дөрөв. Шалгалтад хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл

Тус сумын төсөвт байгууллагууд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Монгол улсын бусад хууль эрх зүйн актуудыг удирдлага болгон ажил үйлчилгээний чанар, бүтээмжийг дээшлүүлэн төсвөөс батлагдсан, төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, эргэлтийн хөрөнгийг олж бэлтгэн байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилттой ажиллаж иржээ.

Шалгагдах хугацааны хөрөнгийн эрх, захирагчийн нэгдүгээр гарын үсгийг Засаг дарга Ч.Нэргүй, Б.Түвшинсайхан, ИТХ-ын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баттулга, ЗДТГ-ын дарга Ш.Даваатогтох, Сургуулийн захирал Б.Оюунчимэг, Цэцэрлэгийн эрхлэгч Г.Бадамхорлоо, Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Т.Туяа, Соёлын төвийн эрхлэгч Н.Мартгүл, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Ч.Аябат, Ү.Ардахгүл, Э.Чулуунцэцэг, Д.Болортуяа, нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж, Санхүүгийн албаны дарга Г.Уртнасан, И.Хишигбаяр, төрийн сангийн мэргэжилтэн Б.Цэлмэгсайхан, Г.Алтантуул нар хяналт тавин ажиллаж ирсэн байна.

Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч Ж.Цэнд-Аюуш Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Улсын байцаагч П.Мягмартүвшин Засаг даргын Тамгын газар, Улсын байцаагч Н.Балт Ерөнхий боловсролын сургууль, Улсын байцаагч У.Гандэмбэрэл Эрүүл мэндийн төв, дотоод аудитор Д.Пүрэвдулам Цэцэрлэг, Соёлын төвийн санхүүгийн баримтыг тус тус шалгалаа.

Тав. Төсвийн бүрдүүлэлт, зарлага санхүүжилтийн талаар

Ховд аймгийн Буянт сум нь татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 2021 онд нийт 86.2 сая төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 111.9 сая төгрөг оруулж, орлогын төлөвлөгөөг 25.7 сая төгрөгөөр илүү буюу 129.8 хувиар давуулан биелүүлжээ.

Шалтгаан нь хөрөнгийн орлого болон ХХОАТ-ын болон бусад орлого давж биелсэнтэй холбоотой байна.

2022 онд нийт 341.4 сая төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 321.7 сая төгрөг оруулж, орлогын төлөвлөгөөг 19.7 сая төгрөгөөр тасалсан буюу 94.2 хувиар биелүүлжээ.

Татварын орлогын төлөвлөгөөг төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

№	Татварын төрөл	2021		2022	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Нийт орлого	86195.0	111952.9	341400.4	321700.4
1	Цалин хөлс, шагнал урамшуулал түүнтэй адилтгах орлого	0.0	0.0	126318.8	132400.0
2	Үйл ажиллагааны орлогын татвар	2000.0	29156.6	27200.0	42881.7
3	ХХОАТ-ын бусад орлого	32600.0	27534.9	23000.0	23500.0
4	Хөрөнгө борлуулсаны орлого	0.0	30.0	23800.0	10579.1
5	Бууны албан татвар	1000.0	960.0	1050.0	1110.0
6	Малын тоо толгойн албан татвар	0.0	10407.5	52986.6	39603.2
7	Улсын тэмдэгтийн хураамж	2000.0	2815.5	2500.0	4505.5
8	Хог хаягдлын хураамж	1700.0	2973.4	3000.0	4503.0
9	Ургамал ашигласны төлбөр	5400.0	5751.1	8000.0	363.0
10	Түгээмэл тархацтай ашигт малтмал	6100.0	7320.0	23000.0	11131.8
11	Ахуйн хэрэглээний ус, рашаан ашигласны төлбөр	16050.0	15290.2	16050.0	17645.7
12	Ан агнуурын нөөц	1276.0	-		2272.8
13	Газрын төлбөр	9269.0	1342.9	25740.0	22743.8

14	Хүү торгууль	8150.0	8370.8	8150.0	8460.8
15	Төсөвт байгууллагын орлого	650.0		605.0	

5.1 Засаг даргын Тамгын газар

Төсвийн бүрдүүлэлт, зарлага санхүүжилтийн талаар

Тус байгууллага нь 2021 онд орон нутгийн төсвөөс 332640.3 мянган төгрөг, өөрийн орлого 605.0 мянган төгрөг, нийт 333245.3 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 324899.6 мянган төгрөг, өөрийн орлого 606.0 мянган төгрөг, нийт 325504.6 мянган төгрөгийн зардал гарган зарцуулж үйл ажиллагаа явуулжээ.

Гарсан зардлаас: Цалингийн зардалд 224890.5 мянган төгрөг, НДШ-д 30144.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 16263.5 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 4079.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 9646.7 мянган төгрөг, шуудан холбоо интернетийн зардалд 4980.0 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлд 335.3 мянган төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгсэлд 167.0 мянган төгрөг, урсгал засварт 2293.0 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 1428.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 3627.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 14792.9 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 12626.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 230.0 мянган төгрөг тус тус зарцуулжээ.

Тайлант 2021 онд авлага эхний үлдэгдэл 301.2 мянган төгрөг байсан бол оны эцэст 14420.0 мянган төгрөг болж өссөн байна. Энэ нь татаас санхүүжилтийн авлага байна.

Оны эхэнд өр төлбөр 89.9 мянган төгрөг байсан бол оны эцэст барагдаж өр төлбөрийн үлдэгдэлгүй болсон байна.

Тайлант 2021 онд үндсэн хөрөнгө оны эхэнд 2266570.2 мянган төгрөг байсан бол оны эцэст 2382228.1 мянган төгрөг болж 115657.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Үндсэн хөрөнгийн өөрчлөлтийг дурдвал барилга байгууламж 83658.8 мянган төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 40867.9 мянган төгрөгөөр, дуусаагүй барилга байгууламж 23228.5 мянган төгрөг нийт 147755.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн, машин тоног төхөөрөмж 13760.6 мянган төгрөгөөр, тавилга эд хогшил 18336.8 мянган төгрөг нийт 32097.5 мянган төгрөгөөр хасагдсан байна.

2022 онд орон нутгийн төсвөөс 366313.4 мянган төгрөг, өөрийн орлого 605.0 мянган төгрөг нийт 366918.4 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж орон нутгийн төсвөөс 360238.3 мянган төгрөг, өөрийн орлогыг бүрдүүлж чадаагүй улмаас нийт 360238.3 мянган төгрөгийн зардал гарган зарцуулж үйл ажиллагаа явуулжээ.

Гарсан зардлыг задалбал: Цалингийн зардалд 239191.8 мянган төгрөг, НДШ-д 30110.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 17568.5 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 2837.5 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 14872.1 мянган төгрөг, шуудан холбоо интернетийн зардалд 2420.0 мянган төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгсэлд 167.0 мянган төгрөг, урсгал засварт 1045.8 мянган төгрөг, нормын хувцас, зөөлөн эдлэл 335.3 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 2137.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 4411.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 29896.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 772.0 мянган төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалд 14472.7 мянган төгрөг тус тус зарцуулжээ.

Тайлант 2022 онд авлагын эхний үлдэгдэл 14420.0 мянган төгрөг байсан бол оны эцэст 140.0 мянган төгрөг болж буурсан байна. Үлдэгдэл авлага нь татаас санхүүжилтийн авлага байна.

Тайлант 2022 онд үндсэн хөрөнгө эхний үлдэгдэл 2382228.1 мянган төгрөг байсан бол оны эцэст 2684138.2 мянган төгрөг болж өсчээ. Тус онд барилга байгууламж 13900.0 мянган төгрөгөөр, тээврийн хэрэгсэл 38610.0 мянган төгрөгөөр нийт 52510.0 мянган төгрөгөөр хасагдаж, зам гүүрийн байгууламж 55689.9 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 17184.9 мянган төгрөгөөр, барилга байгууламж 245545.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Тайлант онд өр төлбөрийн үлдэгдэлгүй байсан бол оны эцэст 10000.0 мянган төгрөг болж өссөн байна. Нэмэгдсэн өр төлбөр нь байгууллагатай холбоотой өглөг байна.

Өмнөх шалгалтын талаар

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Түүвэрт” хамрагдан санал дүгнэлт өгөөгүй байна.

Тайлант 2021 онд сумын ЗДТГ-ын нягтлан бодогч өөртөө аймгийн Засаг даргын захирамж үндэслэн үндсэн цалингийн 20% -иар мөнгөн урамшууллыг 1 сар давхардуулан илүү тооцон авсан 100.0 мянган төгрөг, тайлант онд томилолтын зардал нэг хоног илүү тооцон авсан 100.0 мянган төгрөг нийт 200.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Шатахууны тооцоо бодолтод хяналт хэрэгжүүлээгүй, ковш, күлүгүр, протер, авто машины шатахуун зарцуулалтын тайлан авч хянаагүй, батлагдсан төсөвт багтаан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар захиран зарцуулаагүй, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдаагүй, бараа материал худалдан авсан тухай бүрт нярав орлого аваагүй, зарлагадахдаа нярав нь хүчин төгөлдөр санхүүгийн анхан шатны баримт үндэслэн зарлагадахдаа үлдэгдлийн тооцоо бодоогүй, бараа материалын зарцуулалтад удирдлагаас хэрэгжүүлэх дотоод хяналт сул зэргээс шалтгаалж, 47700.0 мянган төгрөгийн зөрчил илэрчээ.

2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалтай” санал дүгнэлт авсан байна.

ЗДТГ нь овоо тахилга, малчдад тусламж тэтгэмж олгосон, бэлэн мөнгөний кассын тайлан хөтлөөгүй зэрэг нийт 7600.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлсэн байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлаас гадна дараах зөрчил илэрсэнд Улсын ахлах байцагчийн акт тогтоов.

1. Засаг даргын Тамгын газрын дарга Ш.Даваатогтоход 2021 оны 12 дугаар сарын 01-ны №162 тоот төлбөрийн хүсэлтээр томилолтын зардал тооцон олгохдоо 2021 оны 8 дугаар сарын 09-ны өдрийн томилолтоор 1 хоног илүү, 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн томилолт 1 хоног илүү тооцсон, нийт 100,000 төгрөгийг илүү тооцон олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, дэх заалтуудыг,

2. Нягтлан бодогч Д.Болортуяад 2021 оны 2, 3 сарын ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүй 353,264 төгрөгийг, сангийн нягтлан бодогч Ч.Аябатад 416,716 төгрөгийг, нарийн бичиг Б.Цэнд-Аюуш-д 225,164 төгрөг, нийт 995,144 төгрөгийг тус тус илүү тооцон олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 03 дугаар хавсралын 2.7 дахь заалтыг,

3. Нэмэлт санхүүжилтийн дансаар 2022 оны 12 дугаар сарын 24-нд нярав Ш.Амарзаяагийн 5848136601 тоот дансаар 1,498,000 төгрөгийг урьд оны төвлөрүүлсэн усны мөнгө нэрээр гаргаж шинэ жилийн үйл ажиллагаа зохион байгуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.6 дахь заалтыг,

4. Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/203 тоот захирамжаар 5 багийн залуу малчдад тусламж үзүүлэхээр баримт бүрдүүлж

990,000 төгрөгийг нөөц хөрөнгөөс гаргаж багуудын шинэ жилийн үйл ажиллагааг тус бүрд нь 200,000 төгрөгөөр санхүүжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.6 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Дараах зөрчлүүд илэрснийг арилгуулж, дахин давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өглөө.

1. 2021 оны бараа материалын тайланд нүүрс, аргал зэрэг түлш халаалтын материалыг нийт дүнгээр шаардахаар зарлагадсан, зарцуулалт тодорхой бус, шаардахаар өдөрт зарцуулсан зарцуулалт байхгүй, бараа материалын тайланг стандартын дагуу бэлтгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 дахь заалтуудыг,

2. 2021, 2022 оны жолоочийн тооцоог үнэн зөв бодож баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, нярвын тайланг стандартын дагуу гаргаагүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6 дахь заалтууд, санхүү эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 дүгээр тушаал, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалыг,

3. Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал шийдвэр гаргахдаа холбогдох хуулийн заалт бариагүй, Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалаар баталсан “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, Засгийн газрын 2012 оны 150 дугаар тогтоол, 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус зөрчсөн байна.

Шалгалтаар ЗДТГ-т нийт 6,406,251 төгрөгийн зөрчил илрүүлж, 3,583,144 төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт оруулахаар улсын ахлах байцаагчийн 4 акт тогтоож, 2,823,107 төгрөгийн зөрчлийг арилгах хугацаатай үүрэг өгч ажиллалаа.

Дүгнэлт:

Тус байгууллага нь шатах тослох материалын тооцоо бодолт хангалтгүй, томилолтыг буруу тооцдог, тушаал шийдвэргүйгээр цалингийн нэмэгдэл олгодог, хуурамч баримт бүрдүүлж, ажил гүйлгээ хийдэг, нярвын тайланг стандартын дагуу гаргаагүй, өвсний тооцоо бодолт байхгүй, бүртгэлээр тавих хяналт сул байна.

Цаашид авах арга хэмжээний санал:

- Аливаа хөрөнгө мөнгийг бүрдэл болсон, хүчин төгөлдөр анхан шатны баримтаар гүйлгээ хийж байх.
- Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулахад анхаарах.

- Иргэдээс өвс бэлтгэлийн татварт хураан авч байгаа өвсийг унаа, хоол, түлш шатахууны зардал гаргаж бэлтгэж байгаа боловч зарцуулалт хангалтгүй, тайлан тооцоог зах зээлийн үнээр нь бодож татварын орлого бүрдүүлэх.

- Шалгалтаар илэрсэн зөрчилтэй холбоотой зөрчил гаргасан ажилтнуудад ажил сайжруулах хугацаатай үүрэг өгч, биелэлтийг тооцож ажиллах.

Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг оруулсан боловч 2021 онд 27 мэдээллийг хуулийн хугацаа хоцроосон, 2022 онд 14 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож, 10 мэдээллийг огт оруулаагүй байна.

5.2 Орон нутгийн хөгжлийн сангийн талаар

Буянт сумын ОНХС нь 2021 онд 16 ажилд 143438.2 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 123438.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажил, үйлчилгээ хийж гүйцэтгэсэн байна.

Зарцуулалтыг хүснэгтээр харуулбал:

Д/Д	Бараа ажил үйлчилгээ	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1	Сумын гэрэлтүүлэг	15000.0	15000.0
2	Наранхайрхан багийн Бэрхийн улаанд худаг гаргах	15000.0	15000.0
3	Цагаан эрэг багийн Тэрэгтэд худаг гаргах	15000.0	15000.0
4	Тоглоомын талбайд тоглоом суурилуулах	20000.0	20000.0
5	Цагаан эрэг, Нарийн гол, Цагаан бургас багийн төвийн засвар, тохижилт	4579.1	4579.1
6	Эрүүл мэндийн төвд Эхо аппарат худалдан авах	20000.0	20000.0
7	Цагаан эрэг багийн Өлийн худгийн засвар	7000.0	7000.0
8	Сумын төвийн хог цэвэрлэгээ	10000.0	10000.0

9	Улаан хэрээн зам засах	7000.0	7000.0
10	Угталт үдэлтийн талбай засах	2859.1	2859.1
11	Эрүүл мэндийн төвийн гражны засвар	2000.0	2000.0
12	Ковид-19 вирусын эсрэг Эрүүл мэндийн нөөц бүрдүүлэх.	10000.0	
13	Хашаажуулах	10000.0	
14	Ахмадын хөтөлбөр	2000.0	2000.0
15	Боловсролын хөтөлбөр	2000.0	2000.0
16	Залуучуудын хөтөлбөр	1000.0	1000.0
	ДҮН	143438.2	123438.2

Буянт сумын ОНХС нь 2022 онд 30 ажилд 296492.1 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 203900.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажил, үйлчилгээ хийж гүйцэтгэсэн байна.

Зарцуулалтыг хүснэгтээр харуулбал:

Д/Д	Бараа ажил үйлчилгээ	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1	Сумын төвийн бетонон замыг засах	55627.7	55689.9
2	Цагаан эрэг багт мал угаалгын ванны худаг гаргах	25000.0	25000.0
3	Гулсгайд худаг гаргах	33000.0	18000.0
4	Бөхийн дэвжээ авах	20000.0	20000.0
5	Эрүүл мэндийн төвийн хашааг шинэчлэх	20000.0	16000.0
6	Эрүүл мэндийн төвийн гадна зогсоол хийх, сүүдрэвч хийх.	20000.0	11988.0
7	Будаан хард худаг хийх	33000.0	33000.0
8	Тэрбум мод тарих	6000.0	6000.0

9	ISO-9001 стандарт хөтөлбөр	10000.0	
10	Багуудын нутаг дэвсгэрийн хог хаягдлыг цэвэрлэх	10000.0	10000.0
11	Сумын төвийн хог хаягдал цэвэрлэх	10000.0	10000.0
12	Соёлын төвийн тоног төхөөрөмж шинэчлэх	17000.0	17000.0
13	Сумын цагдаагийн хэлтэст драгер төхөөрөмж авах.	7000.0	7000.0
14	Өв соёлын хүрээлэн тохижилтын ажил	10000.0	
15	Багийн Засаг дарга нарын унааны зөрүү	5000.0	5000.0
16	Соёлын төвийн бүжгийн хувцас	8200.0	8200.0
17	Татварын пос машины төлбөр	1000.0	1000.0
18	Цэцэрлэгийн нэг анги тохижуулах	7000.0	7000.0
19	Амны хөндийн эрүүл мэндийн хөтөлбөр	2000.0	2000.0
20	Ахмадын хөтөлбөр	1000.0	1000.0
21	Боловсролын хөтөлбөр	1000.0	1000.0
22	Монгол хэл дэд хөтөлбөр	2000.0	2000.0
23	Аваргууд хөтөлбөр	2000.0	2000.0
24	Ховд цахим хөтөлбөр	5000.0	5000.0
25	Цагаан эрэг багийн малчдын уулзалт зөвлөгөөн, сургалт	5000.0	5000.0
26	Эрүүл мэндийн төвийн грашны засвар	153.4	153.4
27	ОНХС-ийн хяналтын зардалд	1513.3	1513.3
28	Бараа ажил үйлчилгээ ЗДТГ	4924.0	4924.0
29	ЗДТГ-ын тоног төхөөрөмж	3500.0	3500.0
	2022 оны дүн	296492.1	203900.0

Өмнөх шалгалтын талаар

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Түүвэрт” хамрагдан санал дүгнэлт аваагүй байна.

2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалтай” санал дүгнэлт авсан байна.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хүүхдийн цэцэрлэгийн нэг анги тохижуулахад 1824.0 мянган төгрөгийн нийлүүлээгүй хөрөнгийг төлүүлэх акт тогтоосон байна.

2. Монгол банкны мэдээллийн сангийн лавлагаа байхгүй, барьцаа хөрөнгийн жагсаалт, барьцаалсан үнэ эд хөрөнгийн гэрчилгээний эх хувь болон барьцаа хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлээгүй.

3. Байгалийн ургамал ашигласны татварын ашгийн ногдуулалтад хадлан эрхлэгчдээс авсан орлогын тооцоололд хяналт тавиагүй.

4. Тендерийн баримт бичгийг архив үүсгэн хадгалаагүй, тендерт шалгарсан компаний мэдээлэл байдаггүй.

5. Цагаан эрэг багийн Тэрэгтэд гаргасан худгийн үлдэгдэл ажлыг хийж гүйцэтгэх гэсэн зөрчлүүдэд зөвлөмж өгсөн байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар:

Дараах зөрчилд Улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо.

1. 2021 онд “Алтайн газрын хүч” ХХК-тай Цагаан эрэг багийн Тэрэгтэд худаг гаргах ажлыг 15,000,000 төгрөгөөр төсөвлөж 12,000,000 төгрөгийг худаг гаргах, худгийг хамгаалах барилгын ажлыг хийлгэхээр 2021 оны 09 дүгээр сарын 08-ны 03 тоот гэрээ байгуулан 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдөр хүлээн авахаар байсан боловч өнөөдрийг хүртэл уг ажил хийгдээгүй, хүлээн аваагүй байдалтай байгаа хуучин худгийг сэргээн засварлаж эд ангиудыг хүлээлгэн малчинд өгсөн байдалтай байгаа ба Төрийн аудитын албан шаардлагаар үлдэгдэл 4407000 төгрөгт ногдох ажлыг үүрэг болгосон хугацаанд хийж гүйцэтгээгүй нь Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.2 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3.3 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалт, 16.5.5 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.3.1 дэх заалтыг,

2. 2021 оны 06 дугаар сарын 21-ны 01, 02 тоот гэрээгээр “Чандмань Хангай” ХХК сумын байгууллагуудад манжуур шар гэрэл 92 ширхгийг хийхээр ажлын даалгавар төсөвт тусгагдан хийсэн боловч гүйцэтгэлээр 86 ширхэг гэрэл хийж $6 \times 86,000 = 516,000$ төгрөгийн гэрлийг дутуу хийсэн байхад хүлээн авах комисс актад тусган нөхөн хийлгээгүй хүлээн авсан нь Сангийн сайдын 2021 оны 05

дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3.3 дахь заалт, 11 дугаар зүйлийн 11.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.3.1 дэх заалтыг,

3. 2022 оны 09 дүгээр сарын 30-ны 09 тоот гэрээгээр “Таван жин” ХХК -тай гэрээ байгуулан Соёлын төвийн бүжгийн хувцас нийлүүлэх ажлыг 8,200,000 төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн ба уг ажлын даалгаварт бүжгийн 13 гутал нийлүүлэх байтал 9 гутал нийлүүлж 4 гутал буюу 200,000 төгрөгийн ажлыг дутуу нийлүүлсэн нь Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3.3 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.3.1 дэх заалтыг,

4. 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 11 тоот гэрээгээр Наранхайран багийн Гулсгайд худгийн өрөмдлөгийн ажлыг хийлгэхээр “Өлгий Дриллинг ХХК” – тай 18,000,000 төгрөгөөр гэрээ хийсэн ба гүйцэтгэлээр 14,400,000 төгрөгийг олгосон ба худгийг газар дээр нь үзэхэд өрөмдлөгийн ажил хийгдсэн боловч уг ажлыг хүлээж авч комиссын акт үйлдээгүй, данс бүртгэлд тусгаж орлого аваагүй байгаа нь Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3.3 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.3.1 дэх заалтыг,

5. 2022 оны 10 дугаар сарын 27-ны 08 тоот, 09 тоот гэрээгээр сумын Эрүүл мэндийн төвийн хашааны ажил, авто зогсоол тохижилтын ажилд нийт 39,980,000 төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд гүйцэтгэлээр 27,988,000 төгрөг олгосон, цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан 2023 оны 05 дугаар сарын 10 хүртэл гэрээг сунгасан байна. Ажлыг нүдээр үзэхэд бүрэн хийж дуусаагүй гүйцэтгэл 40 хувь орчим явцтай байгаа нь Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3.3 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.3.1 дэх заалтыг,

6. 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 10 тоот гэрээгээр “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд иргэн Ш.Батсайхантай 6,000,000 төгрөгийн гэрээ байгуулсан боловч цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан хойшлуулах хүсэлт өгч гэрээг сунган 05 дугаар сард хийж гүйцэтгэж байгаа боловч ажлыг хүлээн авч акт үйлдээгүй, данс бүртгэлд тусгаагүй нь Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 4.3.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.3.1 дэх заалтыг,

7. 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 17 тоот гэрээгээр амны хөндийн эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд их эмч Б.Энхтуултай 5 өдөр, хүүхдийн цэцэрлэг, сургуулийн дотуур байр, сургуулийн 1, 2 дугаар ангийн сурагчид, сумын бүх төрийн албан хаагчдын эрүүл мэндийн үзлэг оношилгоо хийлгэхээр ажлын даалгаварт тусган гэрээ байгуулсан боловч ажил хүлээлгэн өгсөн тайлангаар зөвхөн 2 өдөр буюу цэцэрлэгийн болон дотуур байрны хүүхдийн үзлэг хийж ажлын даалгавар зөрчиж, ажлыг 60 хувь буюу нийт 95 хүүхэд орхигдуулж үзээгүй байхад ажлын хөлсийг 800,000 төгрөгөөр илүү тооцон олгосон нь Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.2 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.3.1 дэх заалт,

8. 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 08 тоот гэрээгээр “Жаргалын зургаан од” ХХК нь шууд гэрээ байгуулан Ерөнхий боловсролын 12 жилийн сургуульд бөхийн дэвжээ нийлүүлэхээр болсон ба уг дэвжээний тээврийн хөлсийг цаанаас Эрээн хотод, Эрээн хотоос Улаанбаатарт, Улаанбаатараас Ховдод ирэх нийт зардлыг 6,000,000 төгрөгөөр төлөвлөн тээврийн хөлс төлсөн байна. Зах зээлийн ханштай уялдуулан, анхан шатны нотлох баримтгүйгээр 2,000,000 төгрөгийг илүү тооцон төлсөн нь Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.2 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3.3 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.3.1 дэх заалтыг тус тус зөрчсөн.

Дээрх зөрчил дутагдлаас гадна дараах зөрчилд зөвлөмж өглөө.

1. 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 05 тоот гэрээгээр сумын төвийн бетонон зам тавих ажлыг 55,689,993 төгрөгөөр “Чандмань Хангай” ХХК нь

хийж гүйцэтгэсэн ба уг ажлыг хийхдээ төсөв байхгүй, тендерийн бичиг баримт ажлын даалгаварт төсөв шаардаагүй, Улаанбаатар хотын ХХК-ийг шалгаруулан Засаг дарга асан Ц.Нэргүй нь уг ажлыг хийсэн, дунд нь шороон зам 500 метр орчим үлдэж байхад буруу төлөвлөлт хийж, замын багахан хэсгийг хийж гүйцэтгэсэн нь Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.3 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх заалтуудыг,

2. 2022 онд сумын Иргэдийн Нийтийн Хурлаас санал авч эрэмбэлээгүй Цагдаагийн газрын үйл ажиллагаанд зориулж драгер төхөөрөмж авахад зориулж 7,000,000 төгрөгийг зарцуулсан нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.2, 4.6.2 4.4 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6 дахь заалтуудыг,

3. 2022 оны 08 дугаар сарын 05-нд Цагаан эрэг багийн залуу малчдын уулзалт зөвлөгөөний тэмцээний зардалд 5,000,000 төгрөгийг, Засаг даргын Тамгын газрын шатахууны зардалд 4,924,000 төгрөгийг, аваргууд хөтөлбөрийн хүрээнд уралдаан тэмцээний зардалд 3,000,000 төгрөгийг, Ахмадууд хөтөлбөрийн хүрээнд 3,000,000 төгрөгийг нийт 15,924,000 төгрөгийг хөтөлбөр нэрийн дор ЗДТГ-ын урсгал үйл ажиллагаанд зарцуулсан нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.2, 4.5.6, 4.6.2 4.4 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн.

Шалгалтаар нийт 8 хүн, байгууллагатай холбоотой 102,820,000 төгрөгийн зөрчил илрүүлж, 15,516,000 төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт төлүүлэхээр 64,380,000 төгрөгийн ажлыг орлого авч тайлан тэнцэлд тусгуулахаар шийдвэрлэж улсын ахлах байцаагчийн 8 акт тогтоож, 22,924,000 төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх талаар зөвлөмж өгч шийдвэрлэв.

Дүгнэлт:

ОНХС-ийн баримтын бүрдэл хэвийн хэмжээнд явагдаж байгаа боловч хөтөлбөр, арга хэмжээ нэрээр иргэдээс санал ирээгүй байхад ИТХ-ын тогтоолоор сумын Засаг даргын удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой болон Цагдаагийн газар, корона вирус гарсантай уялдан ЗДТГ-ын машины шатахуун, хөрөнгө худалдан авах гэх мэт урсгал зардлыг санхүүжүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 2 дахь хэсэгт заасны дагуу хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг зарим нэг ажлууд дээр оновчтой төлөвлөж чадаагүй, өнөөдрийг хүртэл ажлыг хүлээн аваагүй гэрээг сунгаж хойшлуулдаг хэвшил болсон байна.

2021-2022 онд хийгдсэн ажлууд нь санхүүгийн төсөвгүй, зураггүй ажлын даалгавар тодорхой бус хийгдээгүй 2021 оны худгийн ажлыг өнөөдрийг хүртэл хариуцлага тооцон хүлээн аваагүй, ажил хүлээн авах комисс хариуцлагатай, шударга ажиллахгүй байна.

Цаашид авах арга хэмжээний санал:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сумын удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой урсгал зардал болон хөрөнгийн зардлыг санхүүжүүлэхгүй байх.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж байгаа бүтээн байгуулалтын ажилд гүйцэтгэлийн хяналтыг тогтмол тавих, тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод заагдсан ажлуудын чанар, үзүүлэлтийг бүрэн хангуулж, хүлээн авч байх. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоол зэрэг холбоотой хууль дүрмийг мөрдөх.

3. Сумын иргэдийн санал авч, эрэмбэлсэн саналыг харгалзан олонхийн санал авсан ажлыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах.

4. Ажил хүлээн авах комисс шударга үнэн зөв хариуцлагатай байх.

5. Гэрээний ажлыг хугацаанд нь хийлгэж байх.

6. Улаанбаатар хотын харьяат ХХК-ны нэрийн дор тендер авч ажил үйлчилгээг хийдэг асуудлыг зогсоож, орон нутгийн чанартай хийж гүйцэтгэх ХХК-д давуу эрхийн хүрээнд шударга хандаж нээлттэй шалгаруулж хэвших.

5.3 Сум хөгжүүлэх сангийн талаар

Засгийн газрын 153-р тогтоолын дагуу жижиг дунд үйлдвэрлэл шинээр байгуулах буюу үйл ажиллагаа нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгох зорилтын дагуу зээлийн төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийг Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 13 тоот тогтоолоор Засаг даргаар ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажилласан байна.

2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн хурлын 12 тоот тогтоолоор зээлийн дээд хэмжээг аж ахуйн нэгж байгууллагад 15,000,000 төгрөг, иргэнд 10,000,000 төгрөгөөр зээлийн хүүг жилийн 3 хувь, сарын хүүг 0.25 хувь болгон тогтоосон байна.

Сум хөгжүүлэх сангийн орон тооны бус зөвлөл хуралдаж хурлын шийдвэрийг үндэслэн 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн сумын Засаг даргын А/11 тоот захирамжаар 4 иргэний төсөлд 3 жилийн хугацаатай, 3 хувийн хүүтэйгээр 25000.0 мянган төгрөгийн зээлийг олгосон байна.

1. Р.Дэмбэрэлийн сүү цагаан идээ боловсруулах төсөлд 4000.0 мянган төгрөг
2. О.Туулийн “Чамин үзэг” төсөлд 6000.0 мянган төгрөг
3. Б.Гансүхийн “Таван эрдэнэ” төсөлд 10000.0 мянган төгрөг
4. Ч.Раашийн “Сүү цагаан идээ боловсруулах” төсөлд 5000.0 мянган

төгрөгийн зээлийг дээрх төслүүдэд олгосон байна.

Сум хөгжүүлэх сангийн 2020 оны эхний үлдэгдэл 35980.0 мянган төгрөг байсан ба 45000.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү бусад орлого төлөгдөж, 45000.0 мянган төгрөгийн зээл олгож 35980.0 мянган төгрөг үлдэгдэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн дансны 2021 оны эхний үлдэгдэл 1736.6 мянган төгрөг байсан ба 223069.6 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү бусад орлого төвлөрүүлж 158464.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж 64341.6 мянган төгрөг үлдэгдэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн орон тооны бус зөвлөл хуралдаж хурлын шийдвэрийг үндэслэн 2022 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн сумын Засаг даргын А/150 тоот захирамжаар 5 иргэний төсөлд 3 жилийн хугацаатай, 3 хувийн хүүтэйгээр 80000.0 мянган төгрөгийн зээлийг олгосон байна.

1. Г.Цэнд-Аюушийн Жимсний мод тариалах “Буянтын өгөөж” төсөлд 20000.0 мянган төгрөг
2. Х.Буянхишигийн “Уран ээж” төсөлд 10000.0 мянган төгрөг
3. Я.Баатархүү “Сүүний чиглэлийн үхрийн ферм өргөжүүлэх” төсөлд 20000.0 мянган төгрөг
4. Х.Буянжаргалын “Ааруулан чихэр” төсөлд 10000.0 мянган төгрөг
5. Л.Гантөмөрийн “Хэрчсэн гурил боловсруулах үйлдвэр” төсөлд 20000.0 мянган төгрөгийн зээлийг дээрх төслүүдэд олгосон байна.

Сум хөгжүүлэх сангийн дансны 2022 оны эхний үлдэгдэл 64604.8 мянган төгрөг байсан ба 230733.6 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү бусад орлого төвлөрүүлж, 229522.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж 1210.8 мянган төгрөг үлдэгдэлтэй байна.

Шалгалтаар дараах зөрчил дутагдал илэрч байна.

1. 2021- 2022 онуудад хугацаа хэтэрсэн зээлийг удаа дараа утсаар ярьж мэдэгдсэн гэх боловч албан бичгээр мэдэгдэх хуудас хүргүүлээгүй, дараагийн шатны байгууллагад шилжүүлэн шалгуулах хүсэлт илгээгээгүй байна.

2. 2021-2022 оны зээлийн 82,157,200 төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, хугацаа хэтэрсэн хүүгийн 3,586,700 төгрөгийн нийт 85,743,900 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэр бүхий 113 иргэн байна.

3. Зээл олгох гэрээний 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалтад хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн хоног тутам 0.05 хувиар алданги тооцон төлүүлнэ гэсэн заалтыг зөрчиж 1,290,900 төгрөгт алданги тооцон нэмж төлүүлэхээр мэдэгдэл хүргүүлээгүй тооцон аваагүй байна.

4. Өмнөх онуудын болон 2021-2022 онд хэрэгжсэн зээлийн 40 орчим хувь нь үйл ажиллагаагаа эрхлээгүй байна.

5. Төсөл сонгон шалгаруулахдаа сумын иргэдийн оролцоог хангах ажлыг зохион байгуулах ажлыг зөрчиж, 2021-2022 онд сумын Засаг даргын захирамжаар томилсон нэр бүхий 5 хүний шийдвэрээр олгосон ба уг зөвлөлийг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцээгүй, төсөлд хяналт тавих орон тооны зөвлөл байгуулаагүй, сонгон шалгаруулах төслийг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлээгүй зэрэг нь 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралтын 3.4.1, 3.5.1. 3.3.2 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шалгалтаар хугацаа хэтэрсэн зээл зээлийн хүүтэй холбоотой 85,743,900 төгрөгийг барагдуулах ажлыг зохион байгуулах, алданги тооцон төлүүлээгүй 1,290,900 төгрөгийн зөрчил илэрснийг арилгуулах талаар хугацаатай үүрэг болголоо.

Дүгнэлт:

Сум хөгжүүлэх сангаас олгож буй зээлийг төлүүлэх талаар мэдэгдэх хуудас хүргүүлж ажиллаагүй, Монгол банкны мэдээллийн санд оруулсан хэдий ч зээлийн эргэн төлөлтөд ахиц гараагүй, 113 зээлдэгч зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй, ажлын байр нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх чиг үүрэг нь хэрэгжээгүй байна. Харин 2021-2022 онд олгосон зээлийн 60 хувь нь малчин өрхийг дэмжих, сүү цагаан идээ боловсруулах, жимс ногоо эрхлэх чиглэлээр олгосон ба улирлын чанартай, зориулалтын дагуу ашиглах чиг үүргээ барьж ажиллаж байна.

Өмнөх онуудын хугацаа хэтэрсэн зээлээс хэрэгжиж байгаа зээл байхгүй, 2021-2022 онд хэрэгжсэн зээлийн 40 орчим хувь нь үйл ажиллагаагаа эрхлээгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй, хугацаа хэтэрсэн зээлээ төлөхгүй олон жилээр санхүүжилтийг зогсонги байдалд оруулж байна.

Цаашид авах арга хэмжээний талаарх санал:

1. Хугацаа хэтэрсэн болон үйл ажиллагааны дагуу хэрэгжихгүй байгаа зээлийг барагдуулах талаар мэдэгдэх хуудас өгч хуулийн байгууллагад шилжүүлэн төлүүлэх арга хэмжээ авах ба шинээр зээл олгосон иргэдийн зээлийн зориулалт, үйл ажиллагаанд тогтмол хяналт хийж, зээлийг графикайн дагуу төлүүлэхэд анхаарах.

2. Зээлтэй иргэдийн мэдээлэл Монгол банкны зээлийн мэдээллийн санд орсон талаарх мэдээллийг хугацаа хэтэрсэн зээлтэй иргэдэд ойлгуулан таниулах.

3. Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн сум хөгжүүлэх сангийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт хяналт тавих ажлын хэсгийг шинэчлэн зохион байгуулж, хууль дүрмийг ханган ажиллах.

4. Төсөл сонгон шалгаруулахдаа сумын иргэдийн оролцоог хангах ажлыг зохион байгуулах.

5.4 Хүүхдийн цэцэрлэг

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

Тус байгууллага нь 2021 онд тусгай зориулалтын шилжүүлгээс 303987.8 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 13877.5 мянган төгрөгийн нийт 317865.3 мянган төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 288845.7 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 13877.5 мянган төгрөгийн, нийт 302723.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тус онд цалингийн зардалд 227783.5 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 30760.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 13653.1 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 1604.2 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 391.4 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 85.6 мянган төгрөг, ном хэвлэлийн зардалд 59.6 мянган төгрөг бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсэд 189.7 мянган төгрөг, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 62.8 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 18207.6 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 594.1 мянган төгрөг, урсгал засварын зардалд 160.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 2467.6 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 6703.3 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Оны эхэнд 119.2 мянган төгрөгийн авлагатай байсан бол тайлант хугацааны эцэст авлагагүй болсон байна.

Оны эхэнд 143.3 мянган төгрөгийн өглөгтэй байсан бол тайлант хугацааны эцэст 130.0 төгрөгийн өглөгтэй болсон байна. Энэ нь түлш халаалттай холбоотой 130.0 төгрөгийн өглөг байна.

Үндсэн хөрөнгө оны эхэнд 794068.1 мянган төгрөг байсан бол оны эцэст 799841.1 мянган төгрөг болсон байна.

Хандиваар 3913.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр 1860.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдаж авсан байна.

Тус байгууллага нь 2022 онд тусгай зориулалтын шилжүүлгээс 332169.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 40992.1 мянган төгрөгийн нийт 373161.4 мянган төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 332169.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 40992.1 мянган төгрөгийн, нийт 373161.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тус онд цалингийн зардалд 272629.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 33790.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 17399.5 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 35840.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 160.0 мянган төгрөг, Мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд 814.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 11352.1 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Оны эхэнд авлагагүй байсан бол тайлант хугацааны эцэст 10.1 мянган төгрөгийн авлагатай болсон байна.

Оны эхэнд 130.0 мянган төгрөгийн өглөгтэй байсан бол тайлант хугацааны эцэст 1793.5 мянган төгрөгийн өглөгтэй болж 1663.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Өглөгийг задлан харуулбал: Хоолны өглөг 1663.3 мянган төгрөг, Байгууллагад 28.0 мянган төгрөг, Хувь хүнд 28.0 мянган төгрөг байна.

Үндсэн хөрөнгө оны эхэнд 799841.1 мянган төгрөг байсан бол оны эцэст 806018.0 мянган төгрөг болж, 6176.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Өссөн шалтгаан нь төсвөөс 852.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авсан, Хандиваар ирсэн 770.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4554.0 мянган төгрөгийн тавилга эд хогшилийг нэмж бүртгэсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар:

Тус цэцэрлэгийн нэмэлт санхүүжилтийн 100160015403 тоот дансаар 2021 онд дараах төрлийн гүйлгээнүүд хийгджээ. Үүнд:

- Боловсрол соёл урлагийн газраас ариутгалын зардал аймгийн Засаг даргын А/30 захирамжаар 228738 төгрөг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын

A/452 тоот захирамжаар 120000 төгрөг, A/818 тоот захирамжаар 168500 төгрөг нийт 517238 төгрөгийн орлого орсныг дараах байдлаар зарцуулжээ.

Зарцуулалтыг задалбал:

- Ариутгагч буунд 348738 төгрөг
- Эмийн эргэлтийн сан 168500 нийт 517238 төгрөгийг зарцуулжээ.

Өмнөх шалгалтын талаар:

2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5600.0 төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5600.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн байна.

Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн A/20 тоот ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх тухай тушаалаар 500.0 мянган төгрөгийн, A/21 тоот Багш нарт хүндэтгэл үзүүлэх тухай 650.0 мянган төгрөгийн A/34 тоот багш ажилчдад гарын бэлэг олгох тухай 990.0 мянган төгрөгийн бүгд 2500.0 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг бодитоор тайлагнаагүй байна. Жишээ нь: Байр ашиглалтай холбоотой зардал үр дүнгийн тайлангаар 11900.0 мянган төгрөгийн, мөнгөн гүйлгээний тайлангаар 13600.0 төгрөгөөр тайлагнаж 1700.0 төгрөгийг гүйлгэн зарцуулсан. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр үр дүнгийн тайланд 500.0 мянган төгрөгийг, мөнгөн гүйлгээний тайланд 2500.0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан.

2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3400.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1000.0 мянган төгрөгийн акт, 2400.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн байна.

1. 2020 оны 9 сард иргэн Л.Одгариг гараас нэг бүрийн үнэ 600 төгрөгөөр 3000 кг төмс, 2000 кг лууван худалдан авч нөөцөлсөн байна. Тус байгууллага нь 2021-2022 онд ковид-19 цар тахлаас шалтгаалан ажиллаагүй бөгөөд нөөцөлсөн төмс, луувангаа зарцуулж чадаагүйн улмаас орон нутгийн зах зээлийн ханшаар төмс, лууван кг нь 1800 төгрөг болж, 2020 онд худалдан авсан үнээс 3 дахин нэмэгдсэн байна. 2023 оны 2 сарын байдлаар 1кг-ийг 600 төгрөгөөр худалдан авсан төмс 1200 кг, лууван 621 кг-ийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд 2021-2022 онд нийт 1800 кг төмс, 1379 кг лууван зарцуулжээ. Тус цэцэрлэгийн эрхлэгчийн хүсэлтээр үлдэгдэл

1200*60=720.0 мянган төгрөг, 621*600=372.6 мянган төгрөг, бүгд 1092.6 мянган төгрөгийн төмс, луувангийн үнийг тухайн байгууллагын төсөвт оруулахаар акт тогтоосон байна.

2. Хоолны зардал (210502)-аас гэрэл цахилгааны зардалд 2445.8 мянган төгрөгийг төлсөн нь хангамжийн материалын зардлын төсвийг энэ онд бүгдийг бараа үйлчилгээний бусад зардал дансанд бүртгэж тайлагнасанд зөвлөмж өгсөн байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал:

Дараах зөрчилд Улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо.

1. Эрхлэгчийн 2021.10.24-ны өдрийн А/21 тоот тушаалаар багш нарт хүндэтгэл үзүүлэхэд 600,000 төгрөг, 2021.12.21-ны өдрийн А/34 тоот тушаалаар багш ажилчдын гарын бэлэгт 855,000 төгрөг, 2022.06.13-ны өдрийн А/25 тоот тушаалаар эх үрсийн баяраар ажилчдын хүүхдийн гарын бэлэгт 570,000 төгрөгийг хүүхдийн хоолны зардлаас зарцуулсан, 2022.6.13-ны өдрийн А/21 тоот тушаалаар Ерөнхий боловсролын сургууль төгсөж байгаа ажилчдын хүүхдийн гарын бэлэгт 300,000 төгрөг, 2022.10.12-ны өдрийн А/34 тоот тушаалаар багш нарт хүндэтгэл үзүүлэхэд 588,914 төгрөг, нийт 2,913,914 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн зүйлийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтуудыг, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1, 1.6 дахь заалтуудыг, 2022.04.29-ний өдрийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.5 дахь заалтыг,

2. 2020 оны 9 сард Л.Одгаригаас нэг бүрийн үнэ 800 төгрөгөөр 1 тн манжин худалдан авч нөөцөлсөн боловч 2021-2022 онд ковид-19 цар тахлаас шалтгаалан ажиллаагүй бөгөөд нөөцөлсөн манжин зарцуулж чадаагүй, тооллогоор үлдэгдэл байхгүй, бэлтгэн нийлүүлээгүй байхад үлдэгдлээр бүртгэсэн $574,35 \times 800 = 459,480$ төгрөг байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтуудыг,

3. Нормативт зардал болох хүүхдийн хоолны зардлыг 2021 онд нийт 121,275 төгрөгөөр хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 1 дэх заалтыг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6 дахь заалтуудыг,

4. Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийг танхимаар хичээллүүлэх үйл ажиллагааг хязгаарласан байхад цэцэрлэгийн эрхлэгч

Г.Бадамхорлоод 241,224 төгрөгийн ур чадварын нэмэгдлийг 2021 онд тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн А/35, А/10, 9 тоот тушаал, 2021.02.17-ний өдрийн Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтыг,

5. Эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар туслах Багш Т.Октябрь, Н.Пүрэвсүрэн, Д.Хоролмаа нарт үр дүнгийн урамшууллыг 60 хувиар олгохоор байхад 55 хувиар тооцон 120,691 төгрөг дутуу олгосон нь нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.7 дахь заалтыг,

6. Аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн Б/27 тоот захирамжаар нягтлан бодогчид мөнгөн урамшууллыг үндсэн цалингийн 30 хувиар нэг сар олгох байхад эрхлэгчийн 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/37 тоот тушаалаар Ү.Ардахгүлд 3 сараар олгон, нийт 478,606 төгрөгийг илүү тооцон олгосон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг,

7. Цэцэрлэгийн нягтлан бодогчийг хавсран гүйцэтгэж байгаа Ү.Ардахгүлд ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг үндсэн байгууллагатай давхардуулан 317,938 төгрөгийг илүү тооцон олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг, Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг,

8. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2022 оны 1 сард Галч Л.Одгаригт 15 хувиар олгох байтал 25 хувиар буюу 47,875 төгрөгөөр, Манаач Х.Ганхуягт 10 хувиар олгох байтал 15 хувиар буюу 23,937 төгрөгөөр илүү тооцон олгосон нь Засгийн газрын 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг,

9. Нягтлан бодогч Э.Чулуунцэцэгт 2021 онд тушаал шийдвэргүй, ажил хавсран гүйцэтгэж байгаа байгууллагаас ур чадварын нэмэгдэл 189,290 төгрөг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь заалтыг,

10. Багш нарт 2021 онд ур чадварын нэмэгдлийг ажил дүгнэлгүй 25 хувиар тооцож 1,886,885 төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн А/35А/10/9 тоот тушаалыг,

11. 2023 оны 4 дүгээр сарын байдлаар хүнсний тооллого хийхэд 2023 оны 3 дугаар сард М.Шинэчөдөрөөс байцаа 500 кг-ыг 2700 төгрөгөөр буюу 1,350,000 төгрөгөөр худалдан авч нөөцөлсөн нь муудаж хүүхдийн хүнсэнд нийцэхгүй болсон үлдэгдэл $381.3\text{кг} \times 2700 = 1,029,510$ төгрөг байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтуудыг, 2022 оны Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь заалтуудыг зөрчсөн.

Дээрх зөрчил дутагдлаас гадна дараах зөрчилд зөвлөмж өглөө.

1. 2022 оны 11 дүгээр сард төлбөрийн хүсэлтэд хоёрдугаар гарын үсэг зурж баталгаажуулаагүй, хүнсний үнэ 895,750 төгрөг, шатахууны үнэ 20,000 төгрөгийн төлбөрийн хүсэлт дээр нэг, хоёрдугаар гарын үсэг зурж, тамга дарга баталгаажуулаагүй төрийн сангийн тамга, тэмдэг, гарын үсэггүй гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7 дахь заалтуудыг, Сангийн сайдын 2016 оны 431 тоот тушаалын “Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэх заавар”-ын хавсралтын 3.1 дэх заалтыг, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам мөрдөөгүй,

2. Бүлгийн багш нар журнал дээрх ирцийн бүртгэлээ засварлаж байгаа нь Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын 2021 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн А/71 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Багшлах эрх олгох, хасах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтыг тус тус зөрчсөн.

Шалгалтаар нийт 22 хүн, байгууллагатай холбоотой 8,746,375 төгрөгийн зөрчил илрүүлж, 7,709,934 төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт, 120,691 төгрөгийг нөхөн олгуулахаар шийдвэрлэж улсын ахлах байцаагчийн 10 акт тогтоож, 915,750 төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх талаар зөвлөмж өгч шийдвэрлэв.

Дүгнэлт:

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа хэвийн хэмжээнд явагдаж байгаа боловч хүнсний материалыг талоноос илүү дүнгээр зарцуулсан, ажил хавсран гүйцэтгэж байгаа нягтлан бодогчид ур чадвар, үр дүн олгодог, хүүхдийн хоолны зардлаас гарын бэлэг олгодог, хүнсний материал их хэмжээгээр нөөцөлсөн, үргүй зардал гаргадаг мөн багш нарын ажил дүгнэлгүй хавтгайруулж ур чадварын нэмэгдэл олгодог, багш нарын ирцийн журнал засвартай баллаж, штрик хэрэглэсэн, өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил дахин давтагдсан зэрэг зөрчлүүд гарч байгаа нь Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн зохистой

удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг хэрэгжүүлээгүй, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулаагүй байна.

Цаашид авах арга хэмжээний санал:

1. Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах.
2. Ур чадварын нэмэгдэл олгохдоо журмын дагуу ажил дүгнэж өгч хэвших.
3. Хүүхдийн хоолны зардлаас бэлэг дурсгал гарын бэлэг өгөхгүй байх
4. Хүнсний материал их хэмжээгээр авч нөөцлөхгүй байх
5. Ажил хавсран гүйцэтгэж байгаа нягтлан бодогчид ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал олгохгүй байх
6. Багш нар ирцийн журналыг эмх цэгцтэй баллахгүй хөтлөх
7. Цэцэрлэгийн эрхлэгч Г.Бадамхорлоод сахилгын хариуцлага тооцуулах.

Шилэн дансны талаар:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 151 мэдээллийг хугацаандаа оруулсан байна.

5.5 Ерөнхий боловсролын сургууль

Төсвийн зарлага, санхүүжилтийн талаар:

Тус сургууль нь 2021 онд тусгай зориулалтын шилжүүлгээр 881028.6 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс 39942.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 5800.0 мянган төгрөг, нийт 926770.6 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж, гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлэгээс 880076.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 39942.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 5800.0 мянган төгрөг, нийт 925770.6 мянган төгрөгийн зардал гаргаж үйл ажиллагаа явуулжээ.

Тус онд цалингийн зардалд 709136.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 95734.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 38999.2 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 404.2 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 398.3 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 696.8 мянган төгрөг, ном хэвлэлийн зардалд 261.3 мянган төгрөг, хог хаягдал устгах цэвэрлэх зардалд 193.8 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардалд 914.1 мянган төгрөг, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардалд 601.9 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 32090.5 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 1618.1 мянган төгрөг, урсгал засварын зардалд 941.0

мянган төгрөг, томилолтын зардалд 246.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 720.0 мянган төгрөг, хичээл сургалт үйлдвэрийн зардалд 2953.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 18799.9 мянган төгрөг, үдийн цайны зардалд 21107.4 мянган төгрөг, татан төвлөрүүлэлтэд 952.4 мянган төгрөг, нийт 925816.3 мянган төгрөг зарцуулжээ.

Тус байгууллагын 2021 оны авлагын эхний үлдэгдэл 3552.6 мянган төгрөг байсан бол оны эцэст 13302.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болж, 9750.2 мянган төгрөгөөр өссөн байна. Өр төлбөрийн эхний үлдэгдэл 5304.9 мянган төгрөг байсан бол оны эцэст 1112.6 мянган төгрөг болж, 4192.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 1801807.9 мянган төгрөг байсан бол оны эцэст 1805911.8 мянган төгрөг болж өссөн байна. Тайлант онд дараах хөрөнгүүд нэмэгдсэн байна. Үүнд машин тоног төхөөрөмж 10149.8 мянган төгрөгөөр, Тавилга, эд хогшил 10866.6 мянган төгрөгөөр, ном фонд 150.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн бол номын фондыг 17062.7 мянган төгрөгөөр хасагдуулж акталсан байна. Тайлант онд 73894.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулжээ. Тус байгууллагын нэмэлт санхүүжилтын дансаар 32555.6 мянган төгрөгийн гүйлгээ хийгдэж дараах байдлаар зарцуулсан байна. Үүнд:

- Түлш халаалтын зардалд- 1858.0 мянган төгрөг
- Хангамжийн материалын зардалд – 15967.0 мянган төгрөг
- Урсгал засварын зардалд – 2500.0 мянган төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд- 7479.3 мянган төгрөг
- Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардалд

4751.2 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тус сургууль нь 2022 онд Улсын төсвөөс 1115253.2 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс 100376.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 9915.0 мянган төгрөг, нийт 1236330.7 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 1115253.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 100022.3 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 4915.0 мянган төгрөг, нийт 1218479.8 мянган төгрөгийн зардал гаргаж үйл ажиллагаа явуулжээ.

Тус онд цалингийн зардалд 878639.4 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 109730.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 42078.2 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 60126.5 мянган төгрөг, урсгал засварын зардалд 941.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1986.5 мянган төгрөг, хичээл сургалт үйлдвэрийн зардалд 11605.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 54190.7 мянган төгрөг, үдийн цайны зардалд 51808.2 мянган төгрөг, нийт

1220097.3 мянган төгрөг зарцуулжээ. Тус байгууллагын 2022 оны авлагын эхний үлдэгдэл 13302.9 мянган төгрөг байсан бол оны эцэст 302.9 мянган төгрөг болж авлага буурсан байна. Өр төлбөрийн эхний үлдэгдэл 1112.6 мянган төгрөг байснаа оны эцэст 1516.5 мянган төгрөг болж, өссөн үзүүлэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 1805911.8 мянган төгрөг байсан бол оны эцэст 1895842.8 мянган төгрөг болж 89931.0 мянган төгрөгөөр өссөн байна. машин тоног төхөөрөмж 64854.5 мянган төгрөгөөр, 45028.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдаж, 19826.4 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар авсан байна. Тавилга, эд хогшил 21366.0 мянган төгрөгөөр, 20000.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар 1366.0 мянган төгрөгийн хөрөнгийг төсвөөс худалдан авсан байна. номын фонд 890.5 мянган төгрөгөөр, бусад үндсэн хөрөнгө 2820.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Тайлант онд 74856.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулжээ.

Өмнөх шалгалтын талаар:

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 20800.0 мянган төгрөгийн зөрчил илэрч 17400.0 мянган төгрөгийн алдааг залруулж 3400.0 мянган төгрөгийн алдаа зөрчил дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч ажилласан байна. Үүнд:

- Тус сургууль 3 үүрэн холбооны компаниудтай түрээсийн гэрээ хийж ажилладаг ба тус орлогын батлагдсан орлогын төлөвлөгөө 5800.0 мянган төгрөг гүйцэтгэлээр 7800.0 мянган төгрөгийг оруулж 1900.0 мянган төгрөгийн давсан орлогыг түлш халаалтын зардалд зарцуулсан байна.

- Төрийн сангийн харилцах дансаар гэрэл цахилгааны зардалд 9300.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байхад мөнгөн гүйлгээ, үр дүнгийн тайланд гэрэл цахилгааны зардлыг 8000.0 мянган төгрөгөөр тайлагнаж зөрүү 1300.0 мянган төгрөгийг түлш халаалтын зардалд тайлагнасан байна.

2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна. Тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар 15300.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 10100.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 5200.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт бичиж ажилласан байна. Үүнд:

- Сургуулийн захирлын тушаалаар нэр бүхий 24 багшид нийт 5169.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосонд төлбөрийн акт тогтоосон.

- Байрны хүүхдийн хоолны зардлаас үдийн цай хөтөлбөрт 3642.0 мянган төгрөгийн, бараа материалын зардалд 805.0 мянган төгрөгийн, тээврийн хөлсөнд

1000.0 мянган төгрөгийг хоолны зардлаас зардал зүйл анги зөрчиж олгосон бараа үйлчилгээний бусад зардлаас цахилгааны төлбөрт 4275.0 мянган төгрөг, дотуур байрны хүүхдийн хоолны нормативаас 409.3 мянган төгрөгийг илүү зарцуулсанд зөвлөмж өгсөн байна.

Шилэн дансны талаар:

Тайлант хугацаанд шилэн дансанд 141 мэдээлэл оруулахаас 139 мэдээллийг хугацаандаа мэдээлж 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ удаагийн шалгалтаар дараах зөрчил илэрлээ.

Дараах зөрчил илэрсэнд улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо.

1. Шалгалтаар Ковид-19 цар тахалтай холбоотой 2021 онд сургууль, цэцэрлэгийг танхимаар хичээллүүлэх үйл ажиллагааг хязгаарласан байхад сургуулийн захирал Б.Оюунчимэгт ур чадварын нэмэгдлийг 241,200 төгрөгөөр илүү тооцож олгосон нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн А/35/А10/9 тоот тушаалын 5.1, 9, 10 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8 дахь заалт, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний 2021 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтыг,

2. Сургуулийн сэтгэлзүйч Ш.Анхцэцэгт 2021 оны 1 болон 2 дугаар сард хөдөө орон нутгийн нэмэгдэл цалинг 10 хувиар тооцож 125,200 төгрөгийг олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 2 дахь заалтыг,

3. 2021 оны 9, 10 дугаар саруудад ажилчдад ур чадварын нэмэгдэл цалин олгохдоо хууль тогтоомжид заасан хувь хэмжээнээс илүү тооцсон шалгуур үзүүлэлтээр ажил дүгнэлгүйгээр нэр бүхий 5 ажилтанд нийт 829,400 төгрөгийг илүү олгосон нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 02 дугаар сарын 01- ний өдрийн А/35А/10/9 тушаалын 4.2, 4.3, 4.5 дахь заалтуудыг, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний 2021 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.4 дахь заалтыг,

4. Шалгалтаар 2021-2022 онуудад нэр бүхий 14 ажилтанд салбарын тэргүүний шагналыг дагалдуулан тушаалаар нийт 490,000 төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.7 дахь заалтыг,

5. 2022 оны 1 дүгээр сард ажилчдад ур чадварын нэмэгдэл цалин олгохдоо Засгийн газрын тогтоол, журмын шалгуур үзүүлэлт бариагүй, тушаал шийдвэрийг хүчин төгөлдөр хууль эрх зүйн заалтаар гаргаагүй нэр бүхий 6 ажилтанд 693,200 төгрөгийг илүү олгосон нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/35А/10/9 тушаалын 4.2, 4.3, 4.5 дахь заалтуудыг,

6. Сургуулийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн А/57 тоот тушаалаар 13 ажилтанд ур чадварын нэмэгдэл цалин олгох тушаал гаргаж тайлант онд цалингийн сан хүрэлцээгүйгээс олгогдоогүй байна. Уг ур чадварын нэмэгдэл цалин 1,236,500 төгрөгийг 2021 оны санхүүгийн тайланд өр төлбөрт тусгалгүйгээр 2022 оны 01 дүгээр сард олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг,

7. 2022 оны 5 дугаар сард номын санч О.Золжаргалд бага ангийн багшийн ажил хавсарсны нэмэгдэл цалин олгохдоо 104,100 төгрөгийг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг,

8. Сургуулийн захирал нь өөрийн хамаарал бүхий төрсөн дүү болох Б.Отгонбаярыг ажлын байраар ханган сантехникчийн орон тоонд ажиллуулж, 2022 оны 10 дугаар сард уурын зуухны механикчийн ажил хавсруулан гүйцэтгүүлж ажил хавсарсны нэмэгдэл цалин 170,800 төгрөгийг тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-д заасан “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэснийг зөрчсөн.

9. 2022 онд дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 541,000 төгрөгөөр норм, нормативаас илүү тооцон зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн.

Шалгалтаар 41 хүн, байгууллагатай холбоотой нийт 4,431,400 төгрөгийн зөрчил илрүүлж 4,431,400 төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт оруулахаар улсын ахлах байцаагчийн 8 акт тогтоолоо.

Дүгнэлт:

Тус сургууль санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж хэвшсэн боловч хүүхдийн хоолны зардлыг хэтрүүлсэн, зардлын эдийн засгийн ангилал зөрчиж, ажил гүйлгээ хийсэн, өр, авлага үүсгэсэн зөрчлүүд байна. Цалин хөлс олгохдоо хууль эрх зүйг мөрдөн ажиллахгүй байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлээгүй.

Цаашид авах арга хэмжээний санал:

1. Төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах.
2. Тушаал шийдвэрийг гаргахдаа хуулийн хүрээнд зөв гаргах.
3. Хүүхдийн хоолны норм нормативыг хэтрүүлэхгүй байх.
4. Байгууллагад батлагдаагүй орон тоон дээр ажил хавсруулан гүйцэтгэхгүй байх.
5. Төсвийн жилд өр, авлага үүсгэхгүй, санхүүгийн хариуцлагатай ажиллах.
6. Ажилчдад ур чадварын нэмэгдлийг олгохдоо хууль эрх зүйн хүрээнд засгийн газрын тогтоолын дагуу олгож байх.
7. Төсвийг эдийн засгийн ангилал зөрчихгүй зарцуулах.
8. Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах.
9. Төсвийн жилд өр, авлага үүсгэхгүй, санхүүгийн хариуцлагатай ажиллах.
10. Шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

5.6. Эрүүл мэндийн төв

Төсвийн зарлага, санхүүжилтийн талаар:

Тус байгууллага нь 2021 онд тусгай зориулалтын шилжүүлгээс 387472.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 13794.6 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 34341.3 мянган төгрөг, нийт 440695.5 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 387472.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 13794.6 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 34341.3 мянган төгрөг, нийт 435607.9 мянган төгрөгийн зардал гарган зарцуулж үйл ажиллагаа явуулжээ.

Цалингийн зардалд 321384.5 мянган төгрөг, НДШ-д 44073.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 12472.5 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 1000.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 14680.6 мянган төгрөг, шуудан холбоо интернетийн зардалд 2000.0 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн урсгал, ариутгалд 3203.9 мянган төгрөг, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэлд 19735.1 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 6500.0 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл 2268.8 мянган төгрөг, урсгал засварт 1322.1 мянган төгрөг, багаж, техник, хэрэгсэлд 1000.0 мянган төгрөг, албан томилолт

150.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 951.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 4865.2 мянган төгрөг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн дансаар нийт 106289.6 мянган төгрөгийн орлого, зардлын гүйлгээ цалингийн зардалд 36067.5 мянган төгрөг, НДШ-д 4666.3 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 556.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 2031.6 мянган төгрөг, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэлд 32893.4 мянган төгрөг, албан томилолт 602.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 73.1 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагналд 29400.0 мянган төгрөг тус тус зарцуулжээ.

Тайлант онд үндсэн хөрөнгө оны эхэнд 666600.0 мянган төгрөг байсан бол оны эцэст 703200.0 мянган төгрөг болж 36600.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тус байгууллага нь 2022 онд түүвэрт хамрагдсан байна.

Өмнөх шалгалтын талаар

Тайлант 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт өгчээ.

Дараах зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүнсний материалын тайлан түүврийн зарцуулалттай зөрүүтэй тайлагнасан зөвлөмж өгсөн байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын талаар

Шалгалтын хугацаанд өргөдөл гомдол ирээгүй болно.

Дараах зөрчилд улсын ахлах байцаагчийн акт тогтоов

1. Нягтлан бодогч Ё.Баасанжаргалд 2021 оны 03 дугаар сард 50,000 төгрөгийн томилолтыг илүү тооцон олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, дэх заалтуудыг, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 6 дугаар тогтоолын хавсралтын 2.4 дахь заалтыг

2. 2022 оны зарим саруудад нэр бүхий 6 ажилтанд 1,040,800 төгрөгийг тушаал шийдвэргүй ур чадварын нэмэгдэл цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382-р тогтоолын 4 дүгээр хавсралтын 3 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6 дахь заалтуудыг,

3. Их эмч Б.Ууганцэцэг, сувилагч Э.Ариунчимэг нарт 2022 онд салбарын “Тэргүүн”-ны шагналыг дагалдуулж тус бүрт 100,000 төгрөг, их эмч Д.Баттулга сувилагч Е.Нуржулдыз, нягтлан бодогч Ё.Баасанжаргал нарт 2022 онд салбарын “Жуух бичиг”-ийн шагналыг дагалдуулж тус бүрд 30,000 төгрөг нийт 290,000

төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 43-р тогтоол, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.7 дахь заалтыг,

4. Их эмч Г.Нямзориг 2022 оны 10 дугаар сард 144,736 төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг илүү тооцон олгосон нь Засгийг газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.7 дахь заалтыг,

5. 2022 оны 09 дүгээр сарын 28-ний өдрийн төлбөрийн хүсэлтээр “Шинэ жимс” ХХК-д 500,000 төгрөгийг төсөвлөгдөөгүй зардал гаргаж, үр ашиггүй, хяналтгүй, зориулалт бус зарцуулсан нь Засгийн газрын 2014 оны 147-р тогтоол, Засгийн газрын 2021 оны 43-р тогтоол, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 16.5.1 дэх заалтыг,

6. Эх баригч эмч Ж.Сайханбаярт 2021 оны зарим саруудад мэргэжлийн зэргийн нэмэгдэл 249,708 төгрөгийг олгосон нь Засгийн газрын 2018 оны 382-р тогтоолын 5 дугаар хавсралтын 2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь 16.5.4 дахь 16.5.5 дахь 16.5.6 дахь заалтыг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 дахь заалтыг тус тус зөрчсөн.

Дараах зөрчлүүд илэрснийг арилгуулж, дахин давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өглөө.

1. 2021-2022 онд 4,556,500 төгрөгийг төсвийн зардлын эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2016 оны 431 тоот тушаалын “Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэх заавар”-ын хавсралтын 3.1 дэх заалтыг, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам мөрдөөгүй,

2. 2021 онд тавилга, тоног төхөөрөмж худалдан авахдаа Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолгүйгээр хөрөнгө бэлтгэж, орлогод авсан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтыг,

3. Суудлын автомашинд 2022 оны 11 дүгээр сард “Баруун ойрад” ХХК-аас автомашинд 4ш дугуйг 1,240,000 төгрөг, 2022 оны 12 дугаар сард “Хурд ану билэг” ХХК-аас аккумулятор 255,000 төгрөгөөр авч тавьж олгохдоо авто машины хувийн

хэрэгт баяжилт хийгээгүй, гүйлтийн тооцоо бодоогүй нь Зам тээврийн хөгжлийн сайдын 390 дугаар тушаалын 5 дахь хавсралтыг,

4. 2022 оны Төрийн сангийн бүртгэлээр тавих төрийн сангийн хяналт сул цалин, бараа материалын 6 удаагийн төлбөрийн хүсэлтээр 33,709,419 төгрөгийн төрийн сангийн гарын үсэг, тамга тэмдэг дарж баталгаажуулаагүй байхад шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолын Төрийн сангийн төлбөр тооцооны журмын 7.4, 7.5, 7.6, 7.7, 8.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8 дэх заалтуудыг тус тус зөрчсөн.

Энэ удаагийн шалгалтаар 11 хүн байгууллагатай холбоотой 42,036,163 төгрөгийн зөрчил илэрч, 39,706,919 төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байхаар шалгалтын явцад зөвлөмж өгч, 2,275,244 төгрөгийг аймгийн орон нутгийн төсөвт оруулахаар санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 6 акт тогтоолоо.

Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 151 мэдээллийг хугацаандаа оруулсан байна.

Дүгнэлт

Анхан шатны баримтын бүрдэл, нягтлан бодох бүртгэл хэвийн хэмжээнд явагдаж байгаа боловч, ур чадварын нэмэгдлийг илүү олгож, санхүүгийн сахилга бат сул, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байдлаар зарцуулаагүй, төсвийн зардлын эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн, төрийн сангийн төлбөр тооцоо хийх журам, Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал баталсан Сангийн сайдын журмуудыг мөрдөөгүй, тайлангийн жилд өглөг, авлага үүсгэж Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Цаашид авах арга хэмжээний санал

- Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах.
- Цалин хөлс, урамшууллыг хууль тогтоомж, бусад эрх зүйн актуудын хүрээнд зөв тогтоох.
- Ажилчдад ур чадварын нэмэгдлийг олгохдоо хууль эрх зүйн хүрээнд олгож байх.

- Төсвийг эдийн засгийн ангилал зөрчихгүй зарцуулах.
- Төсвийн жилд өр, авлага үүсгэхгүй, санхүүгийн хариуцлагатай ажиллах.
- Тушаал шийдвэрийг зөв төлөвлөж үндэслэлтэй гаргаж байх.
- Анхан шатны баримтыг бүрдүүлж гүйлгээ хийж байх.

Төсвийн тухай хуулийн 5.1.2-д заасан тайлангийн иж бүрэн, үнэн зөвийг хангаж, Санхүү төсөвтэй холбоотой хууль, эрхзүйг хэрэгжүүлэн ажиллах.

5.7 Соёлын төв

Төсвийн зарлага, санхүүжилтийн талаар:

2021 онд 73164.9 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 73164.9 мянган төгрөг зарцуулж үйл ажиллагаа явуулжээ.

Тайлант онд цалин хөлсөнд 52323.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 6899.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 11279.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 495.0 мянган төгрөг, нормативт зардалд 48.0 мянган төгрөг, урсгал засварт 254.0 мянган төгрөг, томилолтын зардалд 136.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 1396.4 мянган төгрөг, аудит баталгаажуулалтын зардалд 137.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 110.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 250.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Оны эхэнд авлагагүй тайлант хугацааны эцэст авлагагүй байна.

Оны эхэнд өглөггүй байсан тайлант хугацааны эцэст өглөггүй тайлагнасан.

Үндсэн хөрөнгө оны эхэнд 1305655.7 мянган төгрөг байснаа оны эцэст 1311145.5 мянган төгрөг болж, 5489.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвөөс 50.0 мянган төгрөг ном, 2749.1 мянган төгрөгөөр хөрөнгө 8080.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нэмж бүртгэсэн байна. Сумын ИТХ-ын 2021.06.22-ны өдрийн 60 тоот тогтоолоор 1846.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3533.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 5379.3 мянган төгрөгийн эд хөрөнгө, тоног төхөөрөмж акталсан байна.

2022 онд 84984.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 84984.0 мянган төгрөг зарцуулж үйл ажиллагаа явуулжээ.

Тайлант онд цалин хөлсөнд 42285.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 6766.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 10683.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 495.0 мянган төгрөг, нормативт зардалд 48.0 мянган төгрөг, урсгал засварт 354.0 мянган төгрөг, томилолтын зардалд 136.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил

үйлчилгээний төлбөр хураамжид 1506.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 110.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 250.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Оны эхэнд авлагагүй байсан бол тайлант хугацааны эцэст татварын хэлтсээс 310.0 мянган төгрөгийн авлагатай болсон байна.

Оны эхэнд өглөггүй байсан бол тайлант хугацааны эцэст 48.0 мянган төгрөгийн өглөгтэй болсон.

Үндсэн хөрөнгө оны эхэнд 1311145.5 мянган төгрөг байсан бол оны эцэст 1341744.5 мянган төгрөг болж 30599.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Улсын төсвөөс 2499.0 мянган төгрөгийн нөтөбүүк, орон нутгийн төсвөөс 17000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, орон нутгийн хөгжлийн сангаас 8200.0 мянган төгрөгийн бүжгийн хувцас авсан байна.

Шилэн дансны талаар

2021 онд оруулбал зохих мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2022 онд оруулбал зохих мэдээллээ хугацаандаа оруулсан.

Өмнөх шалгалтын талаар:

2021, 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “Түүвэрт” орсон байна.

2021 онд Шинэ жилийн арга хэмжээнд зориулж гацуур мод худалдан авахаар тушаал гаргаж нярвын данслуу 700.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч гацуур модоо хүлээж аваагүй, данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэнд албан шаардлага өгсөн байна.

Шилэн дансны цахим мэдээллийн санд цалингийн зардлаас бусад 5000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээнд санхүүжилтийн мэдээлэл, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, түүнчлэн аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан зэргийг мэдээллээгүйд зөвлөмж өгсөн байна.

2022 онд нийт 7143.7 мянган төгрөгийн зөрчил илэрч, 2617.3 мянган төгрөгийн зөрчлийг залруулж, 4526.4 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Мөнгөн гүйлгээний тайланд нийт орлого, нийт зардлын дүнг зөрүүтэй илэрхийлсэн 2617.3 мянган төгрөгт зөвлөмж өгсөн байна.

Бий биелгээний тэмцээн зохион байгуулахад 1000.0 мянган төгрөг, өв соёлоо дээдлэе 950.0 мянган төгрөг зарцуулахдаа шагнал олгосон гарын үсэг дутуу, анхан шатны баримтын бүрдэл дутууд зөвлөмж,

Говь-алтай аймгийн Баян-уул, Ховд аймгийн Манхан сумын соёлын төвийн ажилчид туршлага судлахаар ирэхэд 1118.0 мянган төгрөгөөр хүнсний материал худалдан авсанд зөвлөмж өгсөн.

Ажилтнуудад үр дүнгийн урамшуулал олгохдоо өөр өөр хувь хэмжээгээр тооцон олгосон Мөн тэтгэмж урамшууллын зардлаас олгосон 1168.4 мянган төгрөгт зөвлөмж өгсөн байна

Шалгалтаар илэрсэн дараах зөрчил, дутагдалд

Дараах зөрчилд Улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо.

1. Байгууллагын даргын 2022.12.12-ны өдрийн А/26 тоот тушаалаар Говь-алтай аймгийн Баян-уул сум, Ховд аймгийн Манхан сумын соёлын төвийн ажилчид туршлага судлахаар ирэхэд 1,250,000 төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн зүйлийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь заалтыг 2022.04.29-ний өдрийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн, Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1, 1.6 дахь заалтуудыг,

2. 2022 онд Монгол улсын аварга О.Хангай, Монгол улсын начин Б.Сосорбарам нарын хүндэтгэлийн үйл ажиллагаанд зориулж 650,000 төгрөгийг зарцуулах байгууллагын даргын тушаал гаргасан боловч тушаал нь он сар өдөр, дугааргүй хүчин төгөлдөр бус баримтаар гүйлгээ хийж, хандив тусламж үзүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.10 дахь заалтуудыг 2022.04.29-ний өдрийн Төрийн хэмнэлтийн тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн 47.1.1, 47.3 дахь заалт, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 3 дугаар зүйлийн 3.1.8.2 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг,

3. Бүжгийн багш Б.Нямдэлгэрт 2022 оны 2 дугаар сард 29,457 төгрөгийн хөдөө орон нутагт ажилласны нэмэгдэл тооцож олгоогүй байгаа нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтыг зөрчсөн.

Дараах зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

1. Нярав М.Алтангүлийн хувийн харилцах дансаар дамжуулан 1,133,460 төгрөгийн бараа материал худалдан авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтуудыг, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журам”-ын 3.2 дахь заалтыг,

2. Байгууллагын даргын 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн А/10 тоот тушаалаар Номын санч Б.Эрдэнэгомбын эхнэр БОЭТ-д цөсний хагалгаанд ороход

байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 10.2 дахь заалт буюу буруу заалт барьж тэтгэмж 90,000 олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг,

3. 2022 оны 12 сард Нэкст электроникс ХХК-аас Dell нөтөбүүк худалдан авахдаа бараа үйлчилгээний зардал /210901/-аас 134,000 төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардал /210801/-аас 2,365,000 төгрөг, нийт 2,499,900 төгрөгийг эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2016 оны 431 тоот тушаалын “Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэх заавар”-ын хавсралтын 3.1 дэх заалт, Сангийн сайдын 2015 оны “Төсвийн зарлагын ангилал”-ыг,

4. Албан хэрэг хөтлөлтийн стандарт мөрдөөгүй, санхүүгийн баримтанд байгаа эрхлэгчийн тушаал архивын баримтанд байхгүй, зарим нь тамга тэмдэг, он сар дугааргүй, цалин шинэчлэн тогтоосон тушаал гаргаагүй байгаа нь Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь заалт, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.2.1.4, 2.2.4, 3 дугаар зүйлийн 3.2.11 дэх заалтуудыг зөрчсөн.

Шалгалтаар нийт 5,651,917 төгрөгийн төлбөр зөрчил илэрч, 1,900,000 төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод, 29,457 төгрөгийг нөхөн олгуулахаар, 3,722,460 төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар зөвлөгөө өгч, улсын ахлах байцаагчийн 3 акт үйлдлээ.

Дүгнэлт:

Тухайн байгууллагад хөтлөгдөж буй НББ болон өмчийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт хэвийн хэмжээнд явагдаж, тайлан балансыг хуулийн хугацаанд гаргаж, зохих байгууллагуудад хянуулан баталгаажуулсан, төсвөөс хүндэтгэл хүлээн авалтанд зардал гаргасан, албан хэрэг хөтлөлтийн стандарт, дүрэм, журам мөрдөөгүй, хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 43 дугаар тогтоол, архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль мөрдөж ажиллаагүй байна.

Цаашид авах арга хэмжээний санал:

1. Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах.
2. Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, дүрэм журам, стандартыг мөрдөж ажиллах.
3. Эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийхгүй байх
4. Цаашид өгсөн заавар зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, гаргасан алдаа, зөрчлийг дахин давтахгүй байх нь зүйтэй.

Зургаа. Буянт сумын төсөвт байгууллагуудад хийсэн шалгалтын дүн

Шалгалтаар нийт сумын хэмжээнд 122 хүн, байгууллагатай холбоотой 159,736,006 төгрөгийн зөрчил илэрч, 71,383,136 төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар зөвлөн, зөрчлийг арилгуулахаар хугацаатай үүрэг өгч, 27,822,722 төгрөгийн төлбөрийг аймгийн орон нутгийн төсөвт оруулахаар 60,530,148 төгрөгийг тухайн байгууллагын төсөвт оруулахаар Улсын ахлах байцаагчийн 39 акт тогтоолоо.

Долоо. Дүгнэлт

Буянт сумын төсөвт байгууллагууд, сангуудын 2021-2022 оны үйл ажиллагаанаас дүгнэн үзэхэд нягтлан бодох бүртгэл хэвийн хэмжээнд явагдаж байгаа боловч анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаагүй, мөнгөн кассын ажиллагааны журмыг хэрэгжүүлээгүй, төсөл хөтөлбөрийг тайлант онд санхүүгийн анхан шатны баримт бүрдүүлж хэрэгжүүлээгүй, төсөл сонгон шалгаруулж байгаа болон хүлээн авч байгаа комисс шударга, хариуцлагатай хандаагүй, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэх зардлыг санхүүжүүлсэн, сум хөгжүүлэх зээл зориулалтын дагуу хэрэгжих тал дээр хангалтгүй, зээлийн эргэн төлөлт байхгүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл хэт өндөр, хүнсний илүүдэл нөөц бүрдүүлж муутган хэрэглэж байсан, хэмнэгдсэн цалингийн зардлыг үрэлгэн зарцуулсан, цалин хөлсийг тушаал шийдвэргүйгээр олгодог, буруу тооцоолдог, ур чадварын нэмэгдэл олгохдоо ажил дүгнэж олгоогүй, цалингийн зардлаас материалын үнэ, засварын зардал, ажлын хөлс олгож, төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж байгаа нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг улам сайжруулж, ажилтнуудын сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар анхаарч ажиллах, хууль, эрхзүйг мөрдөн ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

Дотоод аудитын хороонд:

1. 2021 онд “Алтайн газрын хүч” ХХК-тай Цагаан эрэг багийн Тэрэгтэд худаг гаргах ажлыг 15,000,000 төгрөгөөр төсөвлөж 12,000,000 төгрөгийг худаг гаргах, худгийг хамгаалах барилгын ажлыг хийлгэхээр 2021 оны 09 дүгээр сарын 08-ны 03 тоот гэрээ байгуулан 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдөр хүлээн авахаар байсан боловч өнөөдрийг хүртэл уг ажил хийгдээгүй байхад хяналт тавьж, ажлыг хийлгээгүй гүйцэтгэлд нь ЗДТГ-ын дарга оролцон зураг төсөвт заасныг өөрчлөн өөр худгийг засварлах ажлаар сольж, зөвхөн худгийг ажиллуулах мотор нацос, онгоц, цахилгааны монтаж зэргээр хангаж төсвийг хяналтгүй зарцуулсан ЗДТГ-ын

дарга Ш.Даваатогтох, хариуцан ажиллаж байсан нягтлан бодогч Ч. Аябат нарт сахилгын арга хэмжээ тооцох, актыг хугацаандаа төлж барагдуулахгүй тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах саналыг оруулж байна.

2. 2022 оны татварын орлогод авсан өвсний тооцоог Засаг даргын орлогч Ц.Идэрсайхан, Татварын байцаагч Ү.Баярмаа нарт хариуцуулан зарж борлуулах, тооцоо хийхээр 2022 оны сумын Засаг даргын 08 дугаар сарын 02-ны өдрийн 126 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулсан боловч санхүүгийн тооцоо байхгүй, байгаа тооцоо нь шаардлага хангахгүй, анхан шатны баримт бүрдээгүй тооцоо хийхээр дуудахад Засаг даргын орлогч Ц.Идэрсайхан, Татварын байцаагч Ү.Баярмаа нар аль аль нь би мэдэхгүй гэсэн хариулт өгч тооцоо хийгээгүй тул татварын орлогоор цугласан 2360 ширхэг пресс өвс буюу 11,800,000 төгрөгийн зарцуулалтын асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах саналыг оруулж байна.

3. Цэцэрлэгийн эрхлэгч Г.Бадамхорлоод сахилгын хариуцлага тооцуулах санал оруулж байна.

Найм.Цаашид авах арга хэмжээний санал

1. Сургууль, Цэцэрлэгийн хүүхдийн хоолыг хэт их хэмжээгээр нөөцөлж муутгах чанаргүй байдал үүсгэн зарцуулдаг асуудлыг таслан зогсоох.

2. Төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан санхүүгийн жилийн эхэнд тогтоон, мөрдөж ажиллах ба УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэрийг мөрдөж ажиллах.

3. Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг дагаж мөрдөж дайллага цайллага болон бэлэг дурсгалд төсвийн хөрөнгийг зарцуулахгүй байх.

4. Зардал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх ба гүйлгэсэн тохиолдолд Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4. дэх заалт, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан журмыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

5. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ,ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баримталж ажиллах.

6. Өндөр насны тэтгэвэрт гарахаар тэтгэмжээ авч чөлөөлөгдсөн ажилтанд үндсэн ажилтанаар ажиллуулж цалин хөлс олгохгүй байх.

7. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөд анхаарч ажиллах, хугацаандаа зээлээ төлөөгүй иргэдийг Шүүхэд шилжүүлж, зээлийг төлүүлэх.

8. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжих төсөл хөтөлбөрийг бодитой төлөвлөх, хяналтыг сайжруулж ажиллах.

9.Төсөвт байгууллагуудад өгөгдсөн зөвлөмж, актын төлбөрийг дурдсан хугацаанд барагдуулж, тайланг албан бичгээр Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд 2023 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлэх.

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА



ГӨӨДЭЙ

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
УЛСЫН БАЙЦААГЧ



Ж.ЦЭНД-АЮУШ
П.МЯГМАРТҮВШИН
У.ГАНДЭМБЭРЭЛ
Н.БАЛТ
Д.ПҮРЭВДУЛАМ


ДОТООД АУДИТОР
ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГА
ИТХ-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ:



Б.ТҮВШИНСАЙХАН
Д.БАТТУЛГА
Ш.ДАВААТОГТОХ
Б.ОЮУНЧИМЭГ
Т.ЭНХТУЯА
Н.МАРТГҮЛ
Г.БАДАМХОРЛОО

САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА
ТӨСӨВ, ТӨРИЙН САНГИЙН МЭРГЭЖИЛТЭН
НЯГТЛАН БОДОГЧ:



И.ХИШИГБАЯР
Б.УЯНГА
Г.МӨНХЗАЯА
Ү.АРДАХГҮЛЬ
Г.АЛТАНТУУЛ
Э.ЧУЛУУНЦЭЦЭГ